



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018. он 04. дугаар  
сарын 04-ны өдөр

Дугаар Х.Э/666


Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Мал аж ахуйн талаарх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, малын зүй бус хорогдлоос урьдчилан сэргийлэх, гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажил, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг асуудлаар Танаас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамаар бэлтгүүлэн үүгээр уламжлан хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

000156



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,  
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,  
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2018.03.30 № 01/1002

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танай газраас ирүүлсэн 2018 оны ХЭГ/459 дугаар асуулга хүргүүлэх тухай албан бичигтэй танилцлаа.

Мал аж ахуйн талаарх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Л.Энх-Амгалан нараас Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд хандаж тавьсан асуулгын хүрээнд хариуг бэлтгэн үүгээр хүргүүлж байна.

1. "Монгол мал" хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:  
Хөтөлбөрийн санхүүжилт

д/д	Он	Олгохоор төсөвлөсөн санхүүжилт /тэрбум.төг/	Гүйцэтгэл санхүүжилт /тэрбум.төг/
1	2010	9.5	5.3
2	2011	29.4	27.7
3	2012	60.8	54.9
4	2013	84.1	84.1
5	2014	65.1	65.1
6	2015	50.3	50.3
7	2016	44.9	44.0
8	2017	110.8	89.9
Нийт дүн		435.1	423.3

Хөтөлбөрийн хүрээнд 2017 онд хийсэн гол ажлууд:

№	Арга хэмжээ	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
1	Ноосны урамшуулал	22,637,169.20	22,637,169.20
2	Арьс ширний урамшуулал	10,810,945.10	10,810,945.10
3	Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээ	1,768,000.00	1,768,000.00
4	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	2,000,000.00	2,000,000.00
5	Мах, сүүний үхрийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх	2,500,000.00	2,000,000.00

00000655

6	Нарийн ноост хонины аж ахуйд дэмжлэг үзүүлэх	1,600,000.00	1,600,000.00
7	Каракуль хонины	600,000.00	600,000.00
8	Сүү, махны чиглэлийн үхрийн аж ахуйг өргөтгөх дэмжлэг	800,000.00	800,000.00
9	Сүүний үхрийн бүртгэл мэдээллийн санг өргөтгөх	18,000.00	18,000.00
10	Зохиомол хээлтүүлгийн багаж	50,000.00	50,000.00
11	Малын удмын сангийн үндэсний төвийн цогцолбор	5,595,300.00	5,595,300.00
12	Мал ангилалт, үржлийн ажил үйлчилгээ	200,000.00	200,000.00
13	Малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх	40,000,000.00	20,000,000.00
14	Тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх	600,000.00	300,000.00
15	Мал эмнэлгийн арга хэмжээ	21,600,000.00	21,600,000.00
	Дүн	110,779,414.30	89,979,414.30

УИХ-аар “Малын генетик нөөцийн тухай хууль”, “Малын эрүүл мэндийн тухай хууль” батлагдав.

- Мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах чиглэлээр Засгийн газраас 8.3 тэрбум төгрөгийн асуудлыг шийдвэрлэж, гадаадын төсөл хөтөлбөрүүдээс 2.1 сая ам.долларын тусламж үзүүлснээр том малын зүй бусын хорогдол 606.1 мянга буюу оны эхний нийт малын 0.98 хувийг эзэлж, 21.9 сая төл хүлээн авснаар 2017 оны жилийн эцэст малын тоо 66 сая 215.8 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 4 сая 666.6 мянган толгой буюу 7.6 хувиар өслөө.
- Сүү-ноосны чиглэлийн “Ламын гэгээний улаан” тэмээ, ноолуурын чиглэлийн “Эрчим хар” ямаа, мах-өөх-бүдүүвтэр ноосны чиглэлийн “Сутай” хонь, өөх-мах-бүдүүвтэр ноосны чиглэлийн Цагаан-Уул хонийг үүдрээр тус тус баталгаажуулснаар Монгол улсад баталгаажсан үүлдэр, омгийн малын тоо 47 болов.
- “Малын удмын сангийн үндэсний цогцолбор”-ын эхний ээлжийн бага, дунд төвөгшилтэй барилга, байгууламж ангиллын захиргаа, малын үржүүлэг, биотехнологийн үйлдвэрлэл, лаборатори, малын зориулалттай 18 барилга байгууламж, инженерийн иж бүрэн шугам сүлжээний угсралтын ажлыг хүлээн авав.
- Арвин ашиг шимт үхрийн үржлийн мал бойжуулж борлуулах, тэдгээрийг сайжруулагчаар ашиглах зорилгоор ОХУ-аас 150 толгой махны чиглэлийн герефорд үүлдрийн үхэр, Герман улсаас лимүзэн үүлдрийн 60 толгой үхрийг тус тус импортлон сүү болон сүү-махны, махны чиглэлийн арвин ашиг шимт үхрийн үржлийн аж ахуйг нэмж байгуулав.

- Монгол Улсад үржүүлж буй нарийн, нарийвтар ноост хонины цус сэлбэх, даавууны үйлдвэрийн түүхий эдийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Франц улсаас Махны чиглэлийн нийт 621 толгой үржлийн эм хонь, 36 толгой хуц, бүгд 657 толгой хонийг импортлон үржлийн аж ахуй байгуулав.
- Цэргийн хувцасны зориулалттай каракуль хонины арьсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Говьсүмбэр аймагт үржүүлж буй Сүмбэр үүлдрийн хонины цус сайжруулах зорилгоор Казакстан улсаас 268 толгой хонийг импортлон Монгол улс дахь тус хонины аж ахуйг өргөжүүлэв.
- Цөм сүргийн аж ахуйн арьсны чиглэлийн Сүмбэр хонины аж ахуйд үржүүлж буй хуцнаас 2.2 мянган тун, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд цэврээр үржүүлж буй герефорд үүлдрийн бухнаас 13.6 мянган тун, Дорнод аймагт барга үүлдрийн хуцнаас 4144 тун үр нийт 19.9 мянган тун шаардлага хангасан үр үйлдвэрлэсэн нь дотооддоо үр үйлдвэрлэлийн хамгийн том амжилт боллоо.
- Монгол улсад үржүүлж буй 2015-2016 оны хооронд баталгаажсан 12 үүлдэр, омгийн малын үржил, селекцийн ажлын хөтөлбөрийг шинээр боловсруулж батлуулсан нь цаашид үржлийн ажлыг системтэйгээр хөгжүүлэх үндсэн суурь боллоо.
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 31572.3 мянган толгой, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 421287.6 мянган толгой, лабораторийн оношлогоо, шинжилгээнд 529.9 мянган толгой, гоц халдварт өвчний вакцинжуулалтад 47868.3 мянган толгой малыг хамруулж халдварт өвчнөөр 9.9 мянган мал өвчилснөөс 7.3 мянга буюу 73.3 хувийн, паразиттах өвчнөөр 362.6 мянган мал өвчилснөөс 361.5 мянга буюу 99.6 хувийн эдгэрэлттэй байна.
- Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт 14 улс, оронтой 39 нэрийн хэлэлцээр, харилцан ойлголцолын санамж бичиг, протокол байгуулж, 19 оронтой 46 нэрийн мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ, нөхцөлийг харилцан тохиролцсоноор 2017 онд 29.3 мянган тонн мах экспортлсон нь 2016 оныхоос 3.2 дахин их буюу 229.1 хувиар өссөн дүнтэй байна.
- Энэ онд малчдын өвс, тэжээл 70.2 хувьтай, аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц аймгийн түвшинд 88.5 хувь, сумдын түвшинд 58.5 хувийн биелэлттэй байсанд дүгнэлт гаргаж төсвийн тодотголоор 44.5 тэрбум төгрөгийг батлуулан тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.
- Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой 12 аймгийн 81 сумын нийт 610.0 мянган га, царцаатай 3 аймгийн 16 сумын 89.8 мянган га-д тэмцэх ажлыг зохион байгуулснаар нийт 622.8 мянган га бэлчээрийн талбайг эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэв.

- 2016-2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 149, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 427, гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 62, малчдын санаачилгаар 673, нийт 1356 инженерийн хийцтэй худгийг шинээр барьж ашиглалтанд оруулснаар 2.0 сая га бэлчээр, 6.7 мянган малчин өрх, 3.7 сая мал сүргийг усаар хангах боломжийг бүрдүүлэв.
- "ХАА-н давхар даатгал" ХК-тай хамтран ажилласнаар өнгөрсөн онтой харьцуулахад даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо 22.4 хувь, хураамжийн орлого 23.8 хувиар өслөө.
- Үндэсний үйлдвэрт 20.2 мянган тн ноос тушаасан 86985 малчинд 22.5 тэрбум төгрөг, 3.1 сая ширхэг арьс шир тушаасан 64255 малчинд тушаасан 12.7 тэрбум төгрөг олгож нийт 35.2 тэрбум төгрөгөөр малчдыг орлогожуулав.

2. Малын гаралтай түүхий эдийн ханшийн уналтаас хамгаалах, малчдад учирч буй хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангах зорилтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар:

- Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.50 заалтад "Хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ" гэж заасан зорилт болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд боловсруулсан "Ноолуур" хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Уг хөтөлбөрийн хүрээнд ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилго бүхий ноолуурын хөгжил сан байгуулах, 500 хүртэл тэрбум төгрөгийн тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох" зорилт тусгагдсан.

Иймд Ноолуур хөгжлийн санд шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

3. Засгийн газраас баталсан "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрт туссан малын гаралтай түүхий эдийг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр ойрын хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын талаар:

- Засгийн газрын 2018 оны "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр батлах тухай 36 дугаар тогтоолын талаар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудад мэдээлэл хүргэж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр танилцуулга хийв.
- Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.
- Сангийн яамнаас боловсруулсан Татварын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах санал боловсруулж байна.

- Хөтөлбөрийн хүрээнд байгуулагдах ТЭЗҮ нь хийгдээгүй үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг хийх талаар, аймаг, орон нутаг, төсөл хэрэгжүүлэгч нартай хамтран ажиллаж байна.
- Монгол Хятадын бизнес форумд танилцуулахаар ХХААХҮ-ийн чиглэлээр тэргүүлэх 15 төсөл, түүний дотор “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулагдах томоохон хөрөнгө оруулалт шаардах үйлдвэрийн төсөл, танилцуулгыг( орчуулгын хамт) форумд оролцогчдод хүргүүлэв.
- Хөтөлбөрийн хүрээнд байгуулагдах үйлдвэрт ажиллах мэргэжилтэй ажилтны хэрэгцээ, судалгааг нарийвчлан гаргаж, БСШУЯ, ХНХЯ-тай хамтран ажиллана.
- Түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр олон улсын байгууллага, хандивлагчдын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд түүхий эдийн тордолтын цех байгуулах, малчид хоршоологчдод сургалт явуулах зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

4. “Үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгох” зорилтын хэрэгжилт:

- “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн төслийг Улсын Их Хурал 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж, 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөхөөр шийдвэрлэсэн. Энэ хууль хэрэгжсэнээр мал эмнэлгийн нэгдсэн тогтолцоо бүрэлдэж, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тандалт, судалгаанд тулгуурлан хэрэгжүүлдэг болох нөхцөл бүрдсэн.  
Ингэснээр халдварт өвчний голомтын тоо буурч, улмаар олон улсын худалдааны хорио цээрт гоц халдварт өвчингүй, тайван статустай бүс нутгийн хэмжээ нэмэгдэж, хамгийн гол нь малын гаралтай бүтээгдэхүүн “экспортлох” бизнесийн таатай нөхцөл бүрдэнэ.
- Хуулийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ХХААХҮ-н сайдын 2018 оны А-7 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

5. Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулж буй ажил:

- Шүлхийтэй тэмцэх арга хэмжээг ХХААХҮ-ийн сайдын 2014 онд батлагдсан зааврын дагуу төв, орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагууд хамтран цогц арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2017 оны хавар, намрын улиралд хийгдсэн шүлхийн вакцинжуулалтад давхардсан тоогоор 20 аймгийн 188 сумын 60,916 малчин өрхийн 14,1 сая толгой малыг хамруулж 2,26 тэрбум төгрөгний үйлчилгээний хөлсийг 1,879 мал эмнэлэг, үржлийн нэгжид тус тус олгосон.
- Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 29 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ОХУ-ын Холбооны мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах төвтэй 2,0 сая тун шүлхийн вакцин шууд худалдан авах гэрээ байгуулсан.

ОХУ-аас 2018 онд 7,1 сая тун вакциныг арилжааны шугамаар авахаас эхний ээлжийн 500 мянган тунг хүлээн авч, яаралтай вакцин шаардлагатай байгаа Булган, Орхон, Хэнтий Дундговь, Өмнөговь, Төв, Дорноговь аймгуудад хүргүүлсэн. Энэ жилээс эхлэн өвлийн хүйтэнд вакцин тарьдаг байдлыг зогсоож цаашдаа мал эмнэлгийн халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, тарилгын ажлыг 04-10 дугаар сарын хугацаанд бүрэн хийж дуусгахаар ХХААХҮЯ-наас ажлын төлөвлөгөө гарган мэргэжлийн байгууллагад чиглэл өгч ажиллаж байна.

#### 6. Малын зүй бусын хорогдлын талаар:

- Өвөлжилтийн нөхцөл байдалд УОК-оос “Шуурхай бүлэг” томилон үнэлгээ хийсэн дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын 3 удаагийн тогтоолоор Улсын нөөцийн 10500 тн өвсийг үнэгүй, 8000 тн тэжээлийг 50 хувь хямруулах, зарим аймгийн ХХААГ, ОБГ, хүн эмнэлэгт ариутгалын болон үйлчилгээний автомашин 27-г, 5 нэр төрлийн 41.0 сая төгрөгийн малын эм бэлдмэл, 1.4 тн ариутгалын бодис, ОБГ-уудад 6.0 тн хүнсний зүйл, аймаг бүрт 110.0 сая төгрөг олгоход зориулж нийт 9.2 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргасан нь өнгөрч буй өвлийн хүндрэлийг даван туулахад ач холбогдолтой боллоо.
- Мөн өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлын танилцуулгыг хийн аймаг, сум, малчин өрхийн судалгааг гаргаж өгөх зэргээр мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган байнгын хамтран ажилласны үр дүнд цагаанаар зудтай, зудархуу өвөлжиж буй сумдын малчдад ОУ-ын хүмүүнлэгийн байгууллагуудаас дараах тусламжийг үзүүллээ . Үүнд:
- НҮБ-ын ХХААБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газраас Архангай, Төв, Булган, Өвөрхангай, Завхан аймгийн 5 сумын нийт 504 малчин өрхөөс мах худалдан авч Улаанбаатар хот болон Завхан аймгийн төвийн эмзэг бүлгийн өрхүүдэд тараах, өвс, тэжээлийн тусламж үзүүлэхэд 696.0 сая төгрөгийн, МУЗН-ээс 15 аймгийн 78 сумын 4500 өрхөд 1 тэрбум 267.8 сая төгрөгийн бэлэн мөнгө болон тэжээл, хүнсний багцын, Дэлхийн зөн-Монгол ОУБ-аас Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өвөрхангай зэрэг 6 аймгийн 26 сумын 1840 өрх тус бүрт 300 кг тэжээл буюу 264.0 сая төгрөгийн тус тус тусламж үзүүлэхэд нийт 2 тэрбум 227.8 сая төгрөг зарцууллаа.
- ОХУ-аас өвс, тэжээл импортлох болон үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангахаар малчид, фермерүүдэд нийлүүлэх аж ахуйн нэгжийн төсөл сонгон шалгаруулалтад тэнцсэн 34 аж ахуйн нэгжтэй 40.0 тэрбум төгрөгийн Бодлогын болон Зээлийн гэрээг байгуулан нийт санхүүжилтийн 78.0 хувь буюу 31.1 тэрбум төгрөгийг ААН-үүдэд шилжүүлээд байна.
- 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 34002.7 тонн тэжээл импортлосноос хивэг 10834.5 тн, хорголжин 6088.3 тн, овъёос 1361.3 тн, өвс 712.9 тн, бусад тэжээл 514.6 тн буюу нийт 19511.6 тн-ын борлуулалт хийгдээд байна. Нийт борлуулалтын 56.4 хувь нь бэлэн мөнгөөр, 31.6 хувь нь зээлээр, 8.0 хувь нь ноосны урамшууллаар, 3.7 хувь нь малаар хийгдсэн байна.

- Өвөлжилтийн хүндрэлийг даван туулахад зориулж авсан арга хэмжээнүүдийн үр дүнд улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 850.4 мянган малын хорогдолтой байгаагаас хамгийн их нь Баянхонгор 141.0, Ховд 106.5, Өвөрхангай 102.5, Архангай 89.6, Завхан 84.7, мянган толгой мал тус тус хорогдсон байна. Нийт малын хорогдол нь оны эхний нийт малын 1.2 хувийг эзэлж байгаа нь хэвийн гэж үзэж болохоор байна.

7. Шүлхийтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулж байгаа арга хэмжээ, түүний үр дүн:

- Монгол улсад 2018 он гарсаар нийт 12 аймгийн 39 суманд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин бүртгэгдсэнээс өнөөдрийн байдлаар 8 аймгийн 20 суманд хорио цээрийн дэглэм хэрэгжиж байна.
- Монгол Улсын хэмжээнд 2018 онд шүлхийн 7,2 сая тун вакцин худалдан авахаар төлөвлөснөөс Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор ОХУ-ын үйлдвэрлэгчээс нийт 2,0 сая тун шүлхийгээс сэргийлэх вакциныг шууд гэрээ байгуулж худалдан авахаар шийдвэрлэснээс эхний ээлжийн 500,0 мянган тун вакциныг /324,0 сая төгрөг/ 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч, Өмнөговь, Дундговь, Булган, Дорноговь, Төв, Хэнтий аймгуудад хуваарилан тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр хүргэж, вакцинжуулалтын арга хэмжээ 90,0 /694742 толгой мал/ хувьтай хэрэгжүүлж байна. Дараагийн ээлжийн 4,0 сая тун вакциныг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүлээн авах бэлтгэлийг ханган ажиллаж байна. Вакцинжуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох аймгуудад зөвлөмжийг хүргүүлж, мал эмнэлэг, үржлийн газрын мэргэжилтнүүд арга хэмжээг газар дээр нь мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган зохион байгуулж байна. Вакцин хүлээн авахтай холбоотойгоор вакцинжуулалтад хамруулах аймаг, орон нутаг, малын тоон мэдээллийг шинэчлэн, төлөвлөлтийг хийж байна.
- Булган аймагт үүссэн шүлхийн нөхцөл байдалтай холбоотойгоор УОК, ОБЕГ, МХЕГ, МЭҮГ-ын холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн 2 удаагийн “шуурхай бүлэг” ажиллаж, тэмцэх арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлж байгаа 5 сумдыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласнаар өнөөдрийн Булган аймгийн 6 суманд бүртгэгдээд байсан 6 сумаас 2 сумын хорио цээрийн дэглэмийг буулгаад байна.
- Архангай, Өвөрхангай аймагт үүссэн шүлхийн нөхцөл байдалтай холбоотойгоор Мал эмнэлэг, үржлийн газрын мал эмнэлгийн хэлтсийн дарга Б.Цолмон, гоц халдварт өвчний асуудал, шуурхай хариу арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн С.Батхуяг нар ажиллаж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласнаар шүлхий өвчний тархалтын цар хүрээг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлснээр хяналтад оруулах нөхцлийг бүрдүүлээд байна. Өнөөдрийн байдлаар Архангай аймагт Хотонт, Өгийнуур сумдыг хамарсан нэг голомт /нийт 13 өрх/ идэвхитай байгаа ба голомтын хүрээ тэлэгдээгүй, анхны тогтоосон хүрээнд тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Өвөрхангай аймагт Хархорин суманд нэг голомтод 2 өрх, Арвайхээр суманд нэг голомтод 9 өрхийн хүрээнд халдварыг хяналтад оруулаад байна.



- Шүлхийн оношлогооны бэлэн байдлыг хангах, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийн бэлэн байдлыг хангах зорилгоор төсвийн хөрөнгөөр 2018 онд худалдан авах лабораторийн оношлуур, хэрэглэгдэхүүн болон ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, халдвар хамгааллын хувцасны тендерийг зарлахаар техникийн тодорхойлолт, тендерийн бичиг баримтыг боловсруулж дуусган, тендерийг зарлаж эхлээд байна.
- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагад хүсэлт хүргүүлснээр дутагдалтай байгаа ариутгал, халдваргүйтгэлийн 1 тонн олон найрлагат бэлдмэлийг тус байгууллагаас нийлүүлэхээр болсон.
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн бэлтгэл хангах хүрээнд аймгуудад зохион байгуулж байгаа Хөдөө, аж ахуйн мэргэжилтний зөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуйн яам болон мал эмнэлэг, үржлийн газрын мэргэжилтнүүд оролцон хуулийн таниулга хийхээс гоц халдварт өвчний нөхцөл байдлын мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний заавар зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Хуулийг дагалдан гарах шүлхийн заавар, стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.
- Малчид, малын эмч нарт зориулан сүүлийн үеийн мэдээлэл, мэдлэгээр баяжуулсан шүлхийн зурагт үзүүлэнг хийж тараахаас гадна холбогдох мэдээллийн сайтад нээлттэй байршуулаад байна.
- Мэдээллийн хэрэгслээр шүлхийн болон шүлхийгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна.
- ОХУ-аас хүмүүнлэгийн тусламжаар 2017 онд нийлүүлсэн шүлхийн вакцины мониторингийн үр дүнг ОХУ-аас хүлээн аваад байна.
- Монгол Улсад сүүлийн 2 жилд хэрэглэж байгаа Энэтхэг болон ОХУ-ын үйлдвэрлэгчийн шүлхийн вакцин болон омгийн нийцэл тогтоох, дархлаажилтыг үнэлэх ажлыг 2017 оны 11 дүгээр сард МЭҮГ, МХЕГ, МЭЭСБУЛ, УМЭАЦТЛ-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг гүйцэтгэж эхэлсэн ба 2018 оны 05 дугаар сард үр дүнг нийтэд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна. Уг судалгааны урьдчилсан үр дүнгээр ОХУ-ын үйлдвэрлэгчийн вакцины дархлаа тогтоц 81.9-84.1 хувьтай, Өмнө нь ашиглаж байсан Энэтхэг Улсын үйлдвэрлэгчийн вакцины дархлаа тогтоц 90.0 гаруй хувьтай байна.
- УОК-ын 2 ажлын хэсэг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс шүлхийтэй тэмцэж байгаа арга хэмжээнд үнэлгээ өгөх зорилгоор орон нутагт ажиллаж байна.



Б. БАТЗОРИГ